



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: САГ-2026/149/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор

Ц.Наранчимэг

Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг

Утас: 260512 Цахим хаяг: erdenetsetseg.i@audit.mn

Ахлах аудитор: Ш.Наран

Утас: 261628 Цахим хаяг: baran.sh@audit.gov.mn

Солид юнити аудит ХХК-ийн захирал:

Э.Мөнхтогтох

Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	1
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	17
3.5.3 Нэмэлт төсөв	18
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	22
4.5.1 Завсрын аудитын талаар.....	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Төлбөрийн акт.....	24
5.2 Албан шаардлага	24
5.3 Зөвлөмж.....	27
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТГ	Авилгатай тэмцэх газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН
ЗАХИРАЛ Д.ОТГОНСҮРЭН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/394
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын Үндэсний музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсээс бусад зүйлсийн хувьд энэхүү санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон 29,551.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Чингис Хаан Үндэсний Музейд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 568 дугаар тогтоол бүхий чиглэлийн дагуу шилжүүлсэн 541 дэсийн 5,429 ширхэг хөрөнгүүдийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн хэрэгжилтийг УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-н 57-р параграфын дагуу үл хүлээн зөвшөөрч бүртгээгүй;
- Нью жуулчин турс ХХК-ийн ваучерын орлого болох музейн үзмэрийн 33,340.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн бүртгэлд тусгалгүй, тус компанитай байгуулсан 2025 оны 2-р сарын 07-ны өдрийн OUT/SYX/250212-40 тоот аялал жуулчлалын гэрээний төлбөрт хоорондын тооцоогоор хаасан;
- Анхан шатны болон дэмжих нотлох баримтын бүрдэл хангалтгүй, бүрэн бус баримтыг үндэслэн 82,416.0 мянган төгрөгийн зардал бүртгэсэн ба эдгээрээс үүсэх үр нөлөө нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөлтэй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 46 дугаар зүйлийн 46.5.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.6, 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 20 дугаар зүйлийн 20.2.6 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны сайдын 2025 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн А/327 тоот "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн тооллого хийх тухай" тушаалаар тус музейн тооллогын комисс түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн тооллогыг 2025 оны 9 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, тооллогын үр дүн тайлант хугацааны эцэст 43.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 939,808.3 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 10,000.0 мянган төгрөг нийт 949,808.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 476,655.7 мянган төгрөгийг зарцуулж, 473,152.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	645,917,976.70	963,011,561.29
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	20,200.00	20,000.00
311	Кассад байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банканд байгаа бэлэн мөнгө	20,200.00	20,000.00
33	Авлага	-	507,267,562.59
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	33,340,000.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	-	472,788,704.00
33402	Татвар, нийгмийн даатгалын авлага	-	460,000.90
33510	Бусад авлага-байгууллагаас авах авлага	-	678,857.69
35	БАРАА МАТЕРИАЛ	645,897,776.70	455,723,998.70
35130	Эм боох, материал	140,000.00	140,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	257,571,644.30	177,601,979.40
35410	Бичиг хэрэг	13,517,350.00	10,633,155.00
35420	Аж ахуйн материал	25,016,422.00	15,736,690.00
35440	Түлш, шатах тослох материал	1,950,000.00	590,000.00
35470	Бусад хангамжийн материал	347,702,360.40	251,022,174.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,948,437,638.91	7,916,770,411.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,948,437,638.91	7,916,770,411.97
392	Биет хөрөнгө	8,830,210,838.75	7,801,773,611.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,857,144,733.00	3,857,144,733.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(393,856,044.96)	(463,641,891.72)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,000,000.00	18,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,150,000.00)	(10,950,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж	982,935,616.16	1,000,770,844.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(597,155,565.43)	(673,541,562.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	460,435,875.60	459,277,151.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(225,827,929.18)	(228,368,770.50)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс	4,710,639,417.00	3,815,038,370.55
39217	Бусад үндсэн хөрөнгө-Ном	27,044,736.56	28,044,736.56
393	Биет бус хөрөнгө	118,226,800.16	114,996,800.12
39301	Программ хангамж	15,890,000.00	15,890,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,459,999.84)	(9,689,999.88)
39305	Газар эзэмших эрх	108,796,800.00	108,796,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,594,355,615.61	8,879,781,973.26
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	42,027,617.82
41300	Өглөг	-	42,027,617.82
41361	Байгууллагад өгөх өглөг	-	31,230,304.43
41400	Урьдчилж орсон орлого	-	10,797,313.39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,594,355,615.61	8,837,754,355.44
51	Засгийн газрын хувь оролцоо	1,363,714,164.40	1,363,714,164.40
51200	Хуримтлагдсан үр дүн	2,374,463,162.44	1,565,220,231.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,856,178,288.77	5,908,819,959.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,594,355,615.61	8,879,781,973.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,326,972,812.42	3,178,189,388.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,178,189,388.15
120	Нийтлэг татварын бус орлого	-	45,760,500.01
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	45,760,500.01
122	Тусламжийн орлого	-	3,132,428,888.14
1221	Хандив тусламж/ дотоод/	-	3,132,428,888.14
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,144,832,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	2,144,832,200.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	987,596,688.14
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	977,596,688.14
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,326,972,812.42	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,925,560,100.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,925,560,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,401,412,712.42	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,900,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,297,512,712.42	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,347,924,312.43	3,049,190,772.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,347,924,312.43	3,049,190,772.86
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,079,972,533.63	2,834,957,230.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,528,981,861.00	1,667,267,988.07
210101	Үндсэн цалин	999,844,528.06	1,028,938,371.72
210102	Нэмэгдэл	292,549,882.94	289,397,579.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	188,764,000.00	262,697,292.27
210104	Урамшуулал	47,823,450.00	86,234,744.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	189,544,469.51	208,543,617.19
210201	Тэтгэврийн даатгал	128,783,415.25	143,494,087.17
210202	Тэтгэмжийн даатгал	15,457,099.91	16,668,850.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,259,541.97	8,996,150.58
210204	Ажилгүйдлийн даатгал	6,937,081.54	7,764,765.65
210205	Эрүүл мэндийн даатгал	29,107,330.84	31,519,763.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,596,676.91	68,731,377.31
210301	Гэрэл, цахилгаан	32,326,063.95	39,812,590.38
210302	Түлш, халаалт	23,816,910.49	23,295,750.82
210303	Цэвэр, бохир ус	6,453,702.47	5,623,036.11




**Монголын Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
2104	Хангамж, бараа материалын зардал	307,923,385.20	387,943,872.00
210401	Бичиг хэрэг	13,161,325.00	20,574,835.00
210402	Тээвэр, шатахуун	31,973,015.00	18,555,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,336,590.20	7,096,189.00
210404	Ном, хэвлэл	133,125,215.00	90,260,703.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,301,750.00	6,200,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	118,025,490.00	223,591,712.10
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	21,664,932.00
2105	Нормативт зардал	28,265,000.00	406,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	406,000.00
210502	Хоол, хүнс	28,265,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	136,210,512.00	3,007,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500.00	-
210604	Урсгал засвар	136,206,012.00	3,007,100.00
2107	Томилолт, зочны зардал	90,844,000.00	36,660,000.00
210701	Гадаад албан томилолт	13,310,000.00	-
210702	Дотоод албан томилолт	77,534,000.00	36,660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	432,556,763.00	166,568,124.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	422,905,819.00	152,214,902.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	456,000.00	117,612.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,874.00	345,522.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,202,100.00	2,280,400.00
210807	Газрын төлбөр	704,970.00	704,970.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	5,904,718.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	192,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	303,049,866.01	295,829,151.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,672,907.00	4,760,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	272,376,959.01	291,069,151.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	267,951,778.80	687,022,246.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	92,304,099.54
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	92,304,099.54
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	92,304,099.54
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	91,940,020.86
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	364,078.68

Монголын Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
2132	Бусад урсгал шилжүүлэг	242,424,500.00	121,929,442.86
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,400,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,574,600.00	19,367,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,499,900.00	18,108,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	78,874,742.86
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,950,000.00	5,579,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,527,278.80	-
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	13,529,204.48	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,998,074.32	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(20,951,500.01)	128,998,615.29
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	(938,241,546.43)
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	(938,241,546.43)
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	(938,241,546.43)
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(20,951,500.01)	(809,242,931.14)



Монголын Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,326,972,812.42	3,094,640,529.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,094,640,529.93
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	-	3,094,640,529.93
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,144,832,200.00
1221111	Урсгал санхүүжилтийн орлого	-	2,144,832,200.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	949,808,329.93
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	939,808,329.93
13	Тусламж санхүүжилтийн орлого	3,326,972,812.42	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,925,560,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,401,412,712.42	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс хуваарилсан хөрөнгө	103,900,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,297,512,712.42	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	3,226,586,612.42	3,094,640,729.93
21	Урсгал зардал	3,226,586,612.42	3,094,640,729.93
210	Бараа ажил үйлчилгээний зардал	2,951,434,833.62	2,407,618,483.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,528,981,861.00	1,667,727,988.94
210101	Үндсэн цалин	999,844,528.06	1,012,504,597.09
210102	Нэмэгдэл	292,549,882.94	306,242,661.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	188,764,000.00	250,181,871.53
210104	Урамшуулал	47,823,450.00	98,798,858.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	189,544,469.51	208,543,617.19
210201	Тэтгэврийн даатгалын зардал	128,783,415.25	143,494,087.17
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	15,457,099.91	16,668,850.60
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	9,259,541.97	8,996,150.58
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	6,937,081.54	7,864,765.65
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	29,107,330.84	31,519,763.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,596,676.91	70,069,281.07
210301	Гэрэл цахилгааны зардал	32,326,063.95	41,150,494.14
210302	Түлш халаалтын зардал	23,816,910.49	23,295,750.82
210303	Цэвэр, бохир усны зардал	6,453,702.47	5,623,036.11

Монголын Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
2104	Хангамж бараа материалын зардал	238,851,739.20	122,598,424.00
210401	Бичиг хэргийн материал	27,066,694.00	11,919,840.00
210402	Тээвэр, шатахууны зардал	33,453,015.00	11,605,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн зардал	6,836,590.20	7,096,189.00
210404	Ном хэвлэл	1,170,000.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч устгал	4,247,100.00	6,200,500.00
210406	Бага үнэтэй түргэн эдлэгдэх зүйлс	166,078,340.00	84,776,895.00
2105	Нормативт зардал	41,325,000.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	136,300.00	-
210502	Хоол, хүнс	28,265,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,923,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	166,267,892.00	85,117,900.00
210601	Багаж техник хэрэгсэл	46,405,100.00	66,119,000.00
210602	Тавилга	29,923,600.00	-
210604	Урсгал засвар	89,939,192.00	18,998,900.00
2107	Томилолт зочны зардал	90,014,000.00	35,330,000.00
210702	Дотоод албан томилолт	90,014,000.00	35,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	596,718,988.00	212,111,272.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	584,148,144.00	204,181,768.33
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	456,000.00	117,612.00
210804	Тээврийн хэрэгслийн оношилгоо	95,874.00	345,522.00
210805	Мэдээлэл, технологийн зардал	3,998,500.00	4,163,400.00
210807	Газрын төлбөр	704,970.00	704,970.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	2,315,500.00	2,598,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,134,207.00	6,120,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	410,100.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	36,724,107.00	6,120,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	275,151,778.80	687,022,246.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	565,092,803.54
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	91,940,020.86
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	364,078.68
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	472,788,704.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	249,624,500.00	121,929,442.86
213204	Ажил олгогчоос олох бусад тэтгэмж, урамшуулал	19,574,600.00	19,367,700.00
213305	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,499,900.00	18,108,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	78,874,742.86
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	212,550,000.00	5,579,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг	25,527,278.80	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,998,074.32	-
213305	Нэмэлт санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	13,529,204.48	-



Монголын Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III = I -II)	100,386,200.00	(200.00)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	100,386,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	100,386,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	100,386,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	100,386,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(100,386,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	200.00	(200.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,000.00	20,200.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,200.00	20,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,363,714,164.40	5,856,178,288.77	2,395,414,662.45	9,615,307,115.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,363,714,164.40	5,856,178,288.77	2,395,414,662.45	9,615,307,115.62
Тайлант үеийн үр дүн	-	-	(20,951,500.01)	(20,951,500.01)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,363,714,164.40	5,856,178,288.77	2,374,463,162.44	9,594,355,615.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,363,714,164.40	5,856,178,288.77	2,374,463,162.44	9,594,355,615.61
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	52,641,670.97	-	52,641,670.97
Тайлант үеийн үр дүн	-	-	(809,242,931.14)	(809,242,931.14)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,363,714,164.40	5,908,819,959.74	1,565,220,231.30	8,837,754,355.44



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан


Тайлант хугацаа: 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	2,242,058,000.00	2,052,892,179.14	189,165,820.86	91.6
12	Татварын бус орлого	2,242,058,000.00	2,052,892,179.14	189,165,820.86	91.6
122005	Төсвөөс санхүүжих	2,242,058,000.00	2,052,892,179.14	189,165,820.86	91.6
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,242,058,000.00	2,052,892,179.14	189,165,820.86	91.6
21	Урсгал зардал	2,242,058,000.00	2,052,892,179.14	189,165,820.86	91.6
210	Бараа ажил үйлчилгээний зардал	2,088,711,800.00	1,936,541,736.28	152,170,063.72	92.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,705,261,900.00	1,667,727,988.94	37,533,911.06	97.8
210101	Үндсэн цалин	1,066,107,400.00	1,012,504,597.09	53,602,802.91	95.0
210102	Нэмэгдэл	289,549,500.00	306,242,661.49	(16,693,161.49)	105.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	180,701,000.00	250,181,871.53	(69,480,871.53)	138.5
210104	Урамшуулал	168,904,000.00	98,798,858.83	70,105,141.17	58.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	221,106,600.00	208,543,617.19	12,562,982.81	94.3
210201	Тэтгэврийн даатгалын зардал	155,892,900.00	143,494,087.17	12,398,812.83	92.0
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	16,303,500.00	16,668,850.60	(365,350.60)	102.2
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	8,151,700.00	8,996,150.58	(844,450.58)	110.4
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	8,151,700.00	7,864,765.65	286,934.35	96.5
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	32,606,800.00	31,519,763.19	1,087,036.81	96.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,934,000.00	37,020,295.15	4,913,704.85	88.3
210301	Гэрэл цахилгааны зардал	18,504,900.00	17,519,532.83	985,367.17	94.7
210302	Түлш халаалтын зардал	20,340,500.00	16,509,289.32	3,831,210.68	81.2
210303	Цэвэр, бохир усны зардал	3,088,600.00	2,991,473.00	97,127.00	96.9
2104	Хангамж бараа материалын зардал	4,649,000.00	3,492,613.00	1,156,387.00	75.1
210401	Бичиг хэргийн материал	1,196,500.00	843,800.00	352,700.00	70.5
210403	Шуудан холбоо, интернэтийн зардал	1,197,100.00	1,049,313.00	147,787.00	87.7
210406	Бага үнэтэй түргэн эдлэгдэх зүйлс	2,255,400.00	1,599,500.00	655,900.00	70.9
2106	Эд хогшил урсгал засварын зардал	51,647,200.00	-	51,647,200.00	0
210601	Багаж техник хэрэгсэл	51,647,200.00	-	51,647,200.00	0

Монголын Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	25,377,700.00	19,757,222.00	5,620,478.00	77.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,625,000.00	16,592,000.00	33,000.00	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	-	5,000,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн оношилгоо	368,300.00	195,522.00	172,778.00	53.1
210806	Мэдээлэл, технологийн зардал	1,166,000.00	981,100.00	184,900.00	84.1
210807	Газрын төлбөр/ Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	222,600.00	222,600.00	-	100
10809	Улсын мэдээллийн маягтын зардал	2,082,400.00	1,766,000.00	316,400.00	84.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,648,800.00	-	38,648,800.00	0
213	Урсгал шилжүүлэг	153,346,200.00	116,350,442.86	36,995,757.14	75.9
213204	Ажил олгогчоос олох тэтгэмж, урамшуулал	19,367,700.00	19,367,700.00	-	100
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,174,900.00	18,108,000.00	66,900.00	99.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	115,803,600.00	78,874,742.86	36,928,857.14	68.1
8	Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-	-	-	0
9	Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	-	-	0
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	0
4	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл	-	200.00	-	-
6	Төсвийн байгууллагын мэдээлэл	1.00	1.00	-	100
61	Байгууллагын тоо	1.00	1.00	-	100
62	Ажиллагсдын тоо	56	56	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	39	39	-	100
620003	Үйлчлэх ажилтан	16	16	-	100
65	Орон тооны мэдээлэл	56	56	-	100
650006	Соёл урлаг биеийн тамирын салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСБ)	40	40	-	100
650009	Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагч (ТҮ)	14	14	-	100
650010	Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	2	2	-	100
66	Нийт тэтгэвэрт гарагч	3	3	-	100
660011	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	3	3	-	100



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

		/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	949,808,329.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	949,808,329.93
1311	НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	949,808,329.93
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	939,808,329.93
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	476,655,747.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	476,655,747.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	476,655,747.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,048,985.92
210301	Гэрэл, цахилгаан	23,630,961.31
210302	Түлш, халаалт	6,786,461.50
210303	Цэвэр, бохир усны зардал	2,631,563.11
2104	Хангамж, бараа материалын зардал	119,105,811.00
210401	Бичиг хэрэг	11,076,040.00
210402	Тээвэр, шатахуун	11,605,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,046,876.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,200,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	83,177,395.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,117,900.00
210603	Багаж техник хэрэгсэл	66,119,000.00
210604	Урсгал засвар	18,998,900.00
2107	Томилолт, зочны зардал	35,330,000.00
210701	Дотоод албан томилолт	35,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,474,050.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	187,589,768.33
210803	Даатгалын үйлчилгээ	117,612.00
210804	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00
210805	Мэдээлэл, технологийн зардал	3,182,300.00
210807	Газрын төлбөр/ Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	482,370.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	832,000.00
210902	Хичээл практикийн зардал	6,120,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,579,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,579,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,579,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	473,152,782.68
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(473,152,782.68)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(473,152,782.68)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монголын Үндэсний музей нь 1924 онд байгуулагдсан Монголын түүх, соёлын өвийг судлах, хадгалж хамгаалах, олон нийтэд таниулах зорилготой бөгөөд эртний, дундад зуун, шинэ үеийн түүх болон угсаатны зүйн зэрэг байнгын үзвэрийн танхимуудтайгаар соёлын үнэт зүйлийг эрэн сурвалжилж, нээн илрүүлэх, олж авах, үзмэрийг бүртгэн баримтжуулах, музейн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, үзүүлэн дэглэх, үйлчлэх, гадаад дотоодын үзэсгэлэн зохион байгуулах, боловсрол, танин мэдэхүйн ажил зохион байгуулах, сургалт зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, үр дүнг хэвлүүлэх, түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, үзмэрийг гадаад, дотоод үзэсгэлэнд оролцуулах, иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн соёлын дурсгалт зүйлийг түр хугацаагаар үзэсгэлэн, үзүүлэн дэглэх ашиглах, музей хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хуулиар хориглоогүй бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Монголын Үндэсний музейн зорилго нь Монгол үндэстний соёлын биет болон биет бус өвийг эрэн сурвалжлах, олж цуглуулах, бүртгэн баримтжуулах, сэргээн засварлах, хадгалж хамгаалах, утга агуулга, гарал үүслийг нь шинжлэх ухаанчаар судлан тодорхойлох, хойч үедээ уламжлуулж, олон нийтэд дэлгэн үзүүлж сурталчлан таниулах, оюуны тодорхой эрэлт хэрэгцээг хангах улмаар нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монголын Үндэсний музей нь Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд музейн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын үйл ажиллагаанд Соёл спорт аялал жуулчлал, залуучуудын яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавин ажилладаг бөгөөд тайлант оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монголын Үндэсний музей нь Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна. Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй



тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тус нягтлан бодох бүртгэлийн бодлогод хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” болон “Санхүүгийн тайлангийн заавар”, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын хавсралт “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам” зэрэг тушаалуудын зааварчилгаа мөн үндсэн хөрөнгийн дансны ангилалд тус байгууллагын онцлогт тохирсон өв сангийн ангилал тусгагдаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монголын Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 714,573.6 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20.2	20.0	(0.2)
Авлага	-	507,267.6	507,267.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	645,897.8	455,724.0	(190,173.8)
Үндсэн хөрөнгө	8,948,437.6	7,916,770.4	(1,031,667.2)
Нийт хөрөнгө	9,594,355.6	8,879,782.0	(714,573.6)
Өр төлбөр	-	42,027.6	42,027.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,363,714.2	1,363,714.2	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,856,178.3	5,908,820.0	52,641.7
Хуримтлагдсан үр дүн	2,374,463.1	1,565,220.2	(809,242.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,594,355.6	8,879,782.0	(714,573.6)

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүн данстууд байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдлийн өсөлт нь Нью жуулчин турс ХХК-ийн ваучерын орлого болох музейн үзмэрийн 33,340.0 мянган төгрөгийн орлогыг, Татаас санхүүжилтийн авлага 472,788.7 мянган төгрөгийг тус тус санхүүгийн бүртгэлд тусгаагүй залруулгаар бүртгэсэнтэй холбоотой.
- Бараа материал дансны үлдэгдлийн 190,173.8 мянган төгрөгийн бууралтад 183,625.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 373,798.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,031,667.2 мянган төгрөгөөр буурсан нь Чингис Хаан Үндсэний Музейд ТӨБЗГ-ын 2023 оны 11-р сарын 09-ний өдрийн 568 дугаар тогтоол бүхий чиглэлийн дагуу 541 дэсийн 5,429 ширхэг 936,709.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгүүдийг балансаас балансад шилжүүлсэн болон тайлант хугацаанд нэмж байгуулсан хуримтлагдсан элэгдэлтэй хамааралтай.
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 42,027.6 мянган төгрөгөөр өссөн нь аудит, баталгаажуулалтын төлбөр, харуул хамгаалалтын үйлчилгээ, өмгөөллийн үйлчилгээ, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн тооллогод зориулан авсан зөөврийн компьютерын үлдэгдэл төлбөр, судалгааны ажлын урьдчилж төлөгдсөн төлбөрийн үлдэгдэлтэй хамааралтай байгаа бөгөөд уг өр төлбөр нь төрийн сангаас тогтмол зардлаас бусад зардлыг санхүүжүүлэх эрхийг нээгээгүйтэй холбоотой.

- Хуримтлагдсан үр дүн дансны бууралтад тайлант үеийн алдагдал нөлөөлсөн.

Монголын Үндэсний музей нь санхүү, нягтлан бодох бүртгэлдээ Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний Аcolous 4.0 программ ашиглаж байна. Тус программд тухай бүр шинэчлэлт хийгддэг. Төсвийн байгууллагын бүх шаардлагатай мэдээ тайланг боловсруулж гаргадаг. Төрийн сангийн удирдлагын нэгдсэн систем, цалингийн нэгдсэн системтэй шууд холбогдож байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,929,031.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 2,973,438.5 мянган төгрөгөөр бууруулж, 1,955,592.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ төсвийн төслийг батлахдаа Улсын их хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан 2025 оны төсвийн тухай хуулийн хүрээнд, төрийн хэмнэлтийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт болон Улсын их хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолыг үндэслэсэн байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 286,465.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг 2,242,058.0 мянган төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 2,144,832.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, 97,225.8 мянган төгрөг дутуу санхүүжсэн. Гүйцэтгэлээр 2,052,892.2 мянган төгрөгийг зарцуулж, 91,940.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,052,892.2 мянган төгрөг буюу 91.6 хувьтай байгаа нь ажиллагчидтай холбоотой зардлыг 50,096.9 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардлыг 51,647.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 5,390.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 38,648.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 36,995.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,913.7 мянган төгрөг, хангамж, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг 1,472.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Соёлын өвийн хөтөлбөр	2,242,058.0	2,052,892.2	189,165.8	91.6%
1.1	Үндсэн үйл ажиллагаа	1,962,336.4	1,902,146.8	60,189.6	96.9%
1.2	Уран бүтээл хийлгэх	2,433.0	2,400.0	33.0	98.6%
1.3	Эрдэм шинжилгээний судалгааны ажил	3,000.0	3,000.0	0.0	100.0%
1.4	Харуул хамгаалалт	11,192.0	11,192.0	0.0	100.0%
1.5	Ажил олгогчоос олгох тэтгэмж	115,803.6	78,874.7	36,928.9	68.1%
1.6	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	129,118.1	37,170.6	91,947.5	28.8%
1.7	Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд төрөөс үзүүлэх дэмжлэг	18,174.9	18,108.0	66.9	99.6%



Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ.

Үүнд:

- Төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээний хүрээнд захирлын ажлын албыг татан буулгаж, удирдлага зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн албаны дарга нарын тоог 5 орон тоогоор бууруулан ССАЖЗЯ-нд хүргүүлэн ажилласан.
- МҮОНРТ-тэй хамран Дөрвөн бэрх нэвтрүүлгийг 2,000.0 мянган төгрөгөөр, ном сэтгүүл, үзмэрийн билет хэвлүүлэхэд 28,205.0 мянган төгрөг тус тус зарцуулсан.
- Төлөвлөгөөт 2, захиалгат 10 удаагийн 850 гаруй хүн хамруулсан сургалт зохион байгуулж 8,020.2 мянган төгрөг зарцуулсан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 939,808.3 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 10,000.0 мянган төгрөг нийт 949,808.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 476,655.7 мянган төгрөгийг зарцуулж, 473,152.6 мянган төгрөгийн татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус музей нь тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд худалдан авалтаар 96,626.0 мянган төгрөгийн хэвлэл, бараа болон цэвэрлэгээний материал, үзэсгэлэн дэглэлт, орчуулга, хуулийн зөвлөх үйлчилгээ, нээлтийн үйл ажиллагаатай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авсан.

Нээлттэй тендерийн аргаар худалдан авалт хийх төсөвт өртөгтэй худалдан авалтыг харьцуулалтын арга гэж худалдан авалтын төлөвлөгөөнд тусган худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг журмын дагуу төлөвлөж, тайлагнаагүй.

Худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдсан ажилтан байхгүйгээс нээлттэй тендерийн аргаар худалдан авах ажиллагааг Соёлын өвийн үндэсний төвийн 2 ажилтан болон 1 иргэдийн төлөөлөл буюу нийт 3 гишүүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан. Тухайн үнэлгээний хорооны боловсруулсан тендерийн бичиг баримтад гэрээний тусгай нөхцөлүүдийг тодорхойлж бичээгүй, тендерийн бичиг баримтад тусгасан зарим шаардлагуудыг нотлох баримтгүй, тендерийн бичиг баримт боловсруулж зарлах болон тендерийн нээлт хийж оролцогч шалгаруулах хурлын тэмдэглэлд үнэлгээний хорооны гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй. Үнэлгээний хорооны гишүүдтэй гэрээ байгуулж ажлыг дүгнэсэн баримтгүй.

Лед дэлгэцийн худалдан авалт нь 2024 онд ХАА-ны цахим системээр зохион байгуулагдаж, 2024 оны 11-р сарын 01-ний өдөр Алтай байгууламж ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажлыг 2024 оны 12-р сарын 12-ны өдөр хүртэл хугацаанд хийж дуусахаар гэрээнд тусгасан боловч 2025 оны 9-р сарын 15-ны өдөр ажил дүгнэсэн акт үйлдэж үлдэгдэл төлбөрийг бүрэн шилжүүлсэн. Гэрээнд захиалагч, гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хугацаандаа гүйцэтгээгүй

тохиолдолд ямар нэг хариуцлага тооцох заалт оруулаагүй, Лед гэрэл худалдан авалт суурилуулалт гэж Лед дэлгэц суурилуулалтыг зөрүүтэй утгаар гэрээнд оруулсан нь тухайн гэрээ нь хуулийн хүрээнд хүчин төгөлдөр эсэхийг тодорхойлох боломжгүй байдал үүсгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын Үндэсний музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн музейн санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой цаашид ашиглах боломжгүй бараа материалыг зохих журмын дагуу санхүү бүртгэлээс хасах, бараа материалын дансанд бүртгэлтэй нэгээс дээш жил ашиглагдаж буй үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүдийг цаашид ашиглах боломжтой эсэхийг тогтоон, өмч хамгаалах байнгын зөвлөлдөө танилцуулан зохих шийдвэр гаргаж, данснаас хасах эсвэл дахин үнэлүүлж, өртөг ба цаашид ашиглах хугацааг тогтоолгох албан хүсэлт ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр тайлагнах, ашиглах хөрөнгүүдийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх, балансаас балансад шилжүүлсэн хөрөнгүүдийн дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгүүдтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч бүртгэх, ваучерын орлогын тооцоог нийлэхдээ гүйцэтгэлийг үзвэр үзэгчдийн тоо, хөнгөлөлтийн тоо, мөнгөн дүн, үлдэгдэл зэргийг тусган баталгаажуулах, гэрээний хугацаатай уялдуулан, гэрээний эрх үүссэн хугацаанаас эхлэн тооцоолол хийж бүртгэл тайландаа аккурэл сууриар бүртгэх, байгууллагынхаа үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болох зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Солид Юнити Аудит ХХК-ийн аудитын ахлах менежер Д.Нар-Од, ахлах аудитор Д.Бадамцэцэг, туслах аудитор Э.Цэнддорж, Ж.Отгонжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Н.Тунгалаг, захирал Э.Мөнхтогтох нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Наран, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монголын Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын 3,347,924.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 33,479.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Монголын Үндэсний музейн 2025 оны жилийн эцсийн нийт үйл ажиллагааны зардал нь өмнөх оноосоо 392,799.7 мянган төгрөгөөр буурсан байгаа тул гүйцэтгэлийн материаллагийг



шинэчлэн 2,955,124.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 29,551.3 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан заалтын хүрээнд хэмнэлтийн зарчим баримталж байгууллага бүтэц орон тоог нэмэгдүүлээгүй, хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 1,830,641.7 мянган төгрөгийн зөрчлөөс 1,830,641.7 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим системд орлогын 357,502.3 мянган төгрөгийн 6 гүйлгээг, зарлагын 900,747.8 мянган төгрөгийн 19 гүйлгээг мэдээлээгүй, мөн орлогын 264,685.2 мянган төгрөгийн 18 гүйлгээг, зарлагын 95,584.2 мянган төгрөгийн 19 гүйлгээг хугацаа хоцроосон, 14,173.8 мянган төгрөгийн 2 харилцагчийн худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим системд байршуулах мэдээллийг бүрэн оруулаагүй, хугацаа хоцроосон зөрчлийг таслан зогсоох, арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайлант онд гэрээт харуул хамгаалалт, дохиолол хамгааллын үйлчилгээний 2 багц 100,100.0 мянган төгрөгийн тендерийн бичиг баримтын техникийн тодорхойлолтод тусгагдсан тусгай шаардлагыг нотлох баримтын иж бүрдэл дутуу, ажлын даалгаварт дурдсан үзүүлэлтийг хангасан эсэхийг тодорхойлсон баримтгүй шалгаруулсан байна. Мөн худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд гаднаас хараат бус 3 гишүүн ажиллуулж, ажлыг дүгнэсэн актгүй, ажилласан цагийн бүртгэлийг үндэслэж 1,222.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дугаар заалт "Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй оролцогчийг ерөнхий шаардлага хангагүй гэж үзнэ", 50 дугаар зүйлийн 50.1.2

дугаар заалт " ерөнхий гэрээний нэгдүгээр үе шатны, эсхүл энэ хуулийн 50.1.1-д зааснаас бусад тендер шалгаруулалтын үнэлгээний хороог таваас доошгүй", хуулийн 48 дугаар зүйлийн 48.5-д "Тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална" Тендерийн бичиг баримтын ТШЗ 15.6.2-д "Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээллийг маягтын дагуу ирүүлж 2024 оны 1-12 сард тасралтгүй төлсөн болохыг төрийн мэдээлэл солилцооны хур системээр дамжуулан шалгана " гэж заасантай нийцэхгүй.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны тухай хууль, журмыг мөрдөн ажиллаагүй дэмжих нотлох баримтын бүрдэлгүй, бүрэн бус хангалтгүй баримтыг үндэслэн сонгон шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоох, арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд худалдан авалтаар 96,626.0 мянган төгрөгийн хэвлэл, бараа болон цэвэрлэгээний материал, үзэсгэлэн дэглэлт, орчуулга, хуулийн зөвлөх үйлчилгээ зэрэг ажил үйлчилгээг худалдан авсан. Харьцуулалтын аргаар худалдан авалт хийх төсөвт өртгийн дээд хязгаараас давсан худалдан авалтыг харьцуулалтын арга гэж худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг журмын дагуу төлөвлөж тайлагнаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах" журмын 3.1-т "Захиалагч тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралтын 2 дугаар маягтын дагуу цахим системд боловсруулж, журмын 2.7, 2.8-д заасан төлөвлөгөө батлуулах дарааллын дагуу холбогдох дээд шатны байгууллагад тухайн төсвийн жил дууссан даруйд цахим системээр тайлагнана" гэж заасантай нийцэхгүй.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт хийдэг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг журмын дагуу төлөвлөж, тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоох арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Тус байгууллагад мөрдөгдөж буй НБББББ нь Соёлын сайдын 2022 оны 01-р сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан бодлого бөгөөд тус бодлогод хүчингүй болсон Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын хавсралт "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам", Сангийн Сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" болон "Санхүүгийн тайлангийн заавар" зэрэг тушаалуудын зааварчилгаа мөн үндсэн хөрөнгийн дансны ангилалд тус байгууллагын онцлогт тохирсон өв сангийн ангилал тусгагдаагүй зэргээс үзэхэд холбогдох бодлогын бичиг нь тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасан заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллага өөрийн нөөц боломжийг ашиглан, төсвөөс зардал гаргахгүй өөрийн байгууллагын онцлогт тохирсон НБББББ-ийг боловсруулж батлуулан, дагаж мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомж, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил



үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй, бусад хууль тогтоомж хүрээнд төсвийн зарцуулалт нь нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө, орлого, зардал, худалдан авалт зэрэг данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 110,593.0 мянган төгрөгийн 5 алдааг санхүүгийн тайланд залруулж, 1,618,127.4 мянган төгрөгийн 6 алдааг залруулах зөвлөмж, 112,569.5 мянган төгрөгийн 9 зөрчлийг арилгах зөвлөмжийг тус тус өгч, 356,980.5 мянган төгрөгийн 9 зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр асуудлын бүртгэлд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх 5,050.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага, цаашид сайжруулан ажиллах 2,500.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	3	5,050.0	3	5,050.0	100%
Зөвлөмж	2	2,500.0	2	2,500.0	100%
Нийт дүн	5	7,550.0	5	7,550.0	100%

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

1. Монголын Үндэсний музейн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн тооллогын үр дүн мөн балансаас балансад шилжүүлэн данснаас хассан хөрөнгөд хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн хэрэгжилтийн бүртгэлийг,
2. АТГ-т шалгагдан Эрүүгийн цагдаагийн газарт шилжин шалгагдаж буй Музейн Эрдэм шинжилгээ судалгааны төвөөс зохион байгуулсан Дундговь аймгийн Өндөршил сумын Жаргалант нэртэй XV-48000101 дугаар 377.22 га талбайд Угсаатны зүйн авран хамгаалах судалгаа, Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших Цагаан чулуут нэртэй MV-004646 тусгай зөвшөөрлийн 32.97 га талбайд гүйцэтгэсэн Угсаатны авран хамгаалах судалгаа, Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Баянмөнх сумдын зааг нутаг Гүн бүрд нуурын ёроолд гүйцэтгэсэн археологийн хайгуул судалгааны ажилтай холбоотой гарсан шийдвэр, түүнийг хэрэгжилтийг,
3. Нью жуулчин турс ХХК-иас нэхэмжилсэн тус байгууллагатай байгуулсан 2025 оны 02-р сарын 07-ны өдрийн OUT/SYX/250212-40 тоот Аялал жуулчлалын гэрээний үлдэгдэл төлбөр болох 59,060.0 мянган төгрөгийн (төсвийн хөрөнгөөр бус хариуцан төлөх этгээдээр төлүүлэх) төлбөрийг хэрхэн шийдвэрлэснийг дараагийн аудитаар хянах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 928,030.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 928,030.3 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- ХХОАТ-ын илүү төлөлтийг хасах тэмдэгтэй өглөгөөр бүртгэсэн нь Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн онолын үзэл баримтлал үнэн зөв илэрхийлэл 3.10-3.12-р параграф, тодруулга ба хүлээн зөвшөөрөлт 6.9-р параграф, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй,
- Музейн нэмэлт орлого буюу үйлчилгээний төлбөрийн илүү төлөлтийг хасах тэмдэгтэй авлагаар бүртгэсэн нь Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн онолын үзэл баримтлал үнэн зөв илэрхийлэл 3.10-3.12-р параграф, тодруулга ба хүлээн зөвшөөрөлт 6.9-р параграф, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй,
- Бараа материалыг ангиллыг зөрүүтэй бүртгэсэн нь Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн онолын үзэл баримтлал үнэн зөв илэрхийлэл 3.10-3.12-р параграф, Тодруулга ба хүлээн зөвшөөрөлт 6.9-р параграф, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй,
- Үндсэн хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнийг дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн дансанд бус үнэ төлбөргүй хүлээн авсан орлогод бүртгэсэн нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-17 "Үндсэн хөрөнгө" дахин үнэлгээний загвар 54-р параграф, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй,
- Тоног төхөөрөмж дансанд тавилга, бусад хөрөнгийг бүртгэсэн нь Улсын секторын байгууллагуудын нийтлэг Зорилготой санхүүгийн тайлангийн онолын үзэл баримтлал Үнэн зөв илэрхийлэл 3.10-3.12-р параграф, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-17 "Үндсэн хөрөнгө" хүлээн зөвшөөрөлт 14-17-р параграф, 52-р параграф, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй,
- Музейн үзмэрийн орлого буюу үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг 33,340.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн нь Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн онолын үзэл баримтлал Үнэн зөв илэрхийлэл 3.10-3.12-р параграф, Цаг хугацаандаа байх 3.19-3.20-р параграф, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй,
- Татаас санхүүжилтийн авлагыг дутуу бүртгэсэн нь Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн онолын үзэл баримтлал Үнэн зөв илэрхийлэл 3.10-3.12-р параграф, Цаг хугацаандаа байх 3.19-3.20-р параграф, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй,
- Авран хамгаалах судалгааны орлого, зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн нь Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн онолын үзэл баримтлал Үнэн зөв илэрхийлэл 3.10-3.12-р параграф, Цаг хугацаандаа байх 3.19-3.20-р параграф, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй,
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дансанд гэрэл цахилгааны төлбөр 8,247.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,166.0 мянга, дотоод томилолтын зардал 1,260.0 мянга, нийт 10,673.9 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрүүтэй тайлагнасан нь Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн онолын үзэл баримтлал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,



үнэн зөв илэрхийлэл 3.10-3.12-р параграф, тодруулга ба хүлээн зөвшөөрөлт 6.9-р параграф, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна.

Аудитаар нийт 687,290.1 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд, 3,351.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 183,148.5 мянган төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлж, 500,790.2 мянган төгрөгийн 8 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 687,290.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 657,738.8 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1.Музейн захирлын 2025 оны 10-р сарын 22-ны өдрийн А/149 тоот тушаалын дагуу томилолтоор ажилласан эрдэм шинжилгээний 2 ажилтанд 1,200.0 мянган төгрөгийн үндсэн цалин, судлаачийн ажлын хөлсийг давхардуулан олгосон байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дах заалт "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 2025 оны 1 сарын 3-ны өдрийн АЗ дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэл"-ийн журмын 3 бүлгийн 3.3 дахь заалт "Байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх эдийн засгийн үр өгөөжийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлсэн бөгөөд тэдгээрийг найдвартай хэмжиж болохоор байвал зардлыг хүлээн зөвшөөрнө", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон ажлын хөлсийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээтэй 6 ажилтанд улирлын үр дүнгийн урамшуулал нийт 2,151.4 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй.

Шийдвэрлэсэн нь: Туршилтаар ажиллуулсан 6 ажилтанд олгосон урамшууллыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5.2 Албан шаардлага

1. Археологийн судалгаа, угсаатны зүйн авран хамгаалах судалгааны ажлын хүрээнд албан томилолтоор ажилласан хугацаанд түрээсэлсэн автомашины түрээсийн төлбөр, туслах ажилтны хөлс 41,860.0 мянган төгрөгийн зардлуудыг урьдчилж төлсөн тооцоогоор бүртгээгүй, зарцуулалтын нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийж шууд зардалд тайлагнасан.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх", Сангийн сайдын 2025 оны 1 сарын 3-ны өдрийн АЗ дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэл"-ийн журмын 3 бүлгийн 3.7 дугаар зүйлийн (г)-д "Зардлыг урьдчилан төлөх үед: Дт Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/, Кт Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, (д)-д Урьдчилж төлсөн зардлаас тайлант үед хэрэгжсэн үед: Дт Зардал /нэр төрлөөр/ Кт Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/ бүртгэнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй.

Шийдвэрлэсэн нь: Археологийн судалгаа, угсаатны зүйн авран хамгаалах судалгааны ажлын албан томилолт, автомашин түрээс, ажилтны хөлсийг урьдчилж төлсөн тооцоогоор бүртгэдэггүй, анхан шатны нотлох баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийж, бүртгэл тайланд тайлагнадаг, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Авран хамгаалах судалгааны ажилд томилолтоор ажиллах хугацаанд түрээсэлсэн 3 автомашины шатахууныг олгохдоо жолоочийн тооцооны хуудас дахь машины марк, улсын дугаар нь зөрүүтэй, эхэлсэн, дууссан спидометрийн заалтгүй, километрийн заалтыг нотлох анхан шатны баримтгүйгээр нийт 8,171.9 мянган төгрөгийн шатахууныг зардлаар бүртгэсэн. Жолоочийн тооцооны хуудсанд бичигдсэн автомашины дугаараар Smartcar.mn сайтаас тухайн машины маркийг тулгахад зөрүүтэй байгаа нь баримт бичгийг хуурамчаар үйлдсэн байж болзошгүй, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууныг дараа тооцоогоор бүртгээгүй, зарцуулалтыг нотлох баримтын бүрдэл дутуу, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

3. Анхан шатны болон дэмжих нотлох баримтын бүрдэл хангалтгүй, бүрэн бус баримтыг үндэслэн нийт 12,294.1 мянган төгрөгийн зардал бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д "анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлд анхан шатны болон дэмжих нотлох баримтын бүрдэлгүй, бүрэн бус хангалтгүй баримтыг үндэслэн гүйлгээ хийж, зардалд бүртгэдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

4.Өндөр насны тэтгэвэрт гарч, ажлаас чөлөөлөгдөхөд нэг удаагийн буцалтгүй тусламж олгохдоо нэр бүхий 1 ажилтны төрийн албанд ажилласан жилийн нотлох баримтыг архивлаагүй нийт 52,953.4 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д "анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Төрийн албанд ажилласан хугацааг тооцох үндсэн бичиг баримт нь хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын



дэвтэр байна. Үндсэн бичиг баримтыг үрэгдүүлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагаас олгосон лавлагаа эсхүл төрийн албанд ажилласан хугацааг тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэнэ" гэж заасантай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Өндөр насны тэтгэвэрт гарч буй ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж олгохдоо төрийн албанд ажилласан жилийн нотлох баримтыг архивлаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Палеонтологи, археологийн авран хамгаалах зөвшөөрөл авах зорилгоор судлаач, археологич, докторын зэрэгтэй 1 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан нийт 25,529.1 мянган төгрөгийн цалин, нэмэгдэл, урамшууллыг бүтэн олгосон боловч байнга ажлын байран дээр ажилладаг эсэх нь тодорхойгүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.3 дах заалт "Ажилтны ур чадварын түвшин, гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулсан байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй.

Шийдвэрлэсэн нь: Судлаач, археологич мэргэжилтэнд цалин хөлс олгосон асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэж (байгуулсан хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, зохих журмын дагуу цалин хөлс олгох), зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

6.Нью жуулчин турс ХХК-ийн ваучерын орлого болох музейн үзмэрийн 33,340.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн бүртгэлд тусгалгүй, тус компанитай байгуулсан 2025 оны 2-р сарын 07-ны өдрийн OUT/SYX/250212-40 тоот Аялал жуулчлалын гэрээний зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй бөгөөд тус орлого, зардлыг хоорондын тооцоонд хаасан нь залилан байх эрсдэлтэй байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.5 дах заалт "үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг дараах арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" 46.5.3 "гадаад томилолтын зардлыг санхүүжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.4 дэх заалт "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ" 14.4 "бүх орлого", 14.6 "бүх зардал", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 6.1 дэх заалт "Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого, түүний зарцуулалтыг сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүү байдлын тайлан,орлого зарлагын явцын мэдээнд оруулж, тухайн тайлант оны санхүүгийн болон үр дүнгийн тайланд тусгана" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх" "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого, зардлыг үнэн зөв тайлагнаагүй, орлогыг бүртгэл тайланд дутуу тайлагнадаг, зөрчлийг таслан зогсоох албан албан шаардлага хүргүүлсэн.

7.Өмгөөллийн түрэг ХХК-тай байгуулсан "Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх" №01/56 тоот 3-н сарын хугацаатай, 9,000.0 мянган төгрөгөөр байгуулсан. Уг гэрээнд өмгөөллийн гэрээнд тусгагдсан ажлын даалгавар тодорхой бус байгуулж анхан шатны баримтын иж бүрдэл дутуу зардалд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга,

тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй.

Шийдвэрлэсэн нь: Үйлчилгээ авахаар байгуулж буй гэрээнд гүйцэтгэх үүрэг, ажлын даалгаврыг тусгаагүй байх, гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнээгүй байх зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын насжилттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын дансанд 2025 оны жилийн эцсээр 28,926 ширхэг 12,396.2 мянган төгрөгийн өртөг бүхий үнэт цаас бүртгэлтэй байгаа бөгөөд 2018-2022 онуудад орлогод авсан 10,310 ширхэг 4,020.0 мянган төгрөгийн өртөг бүхий цаашид ашиглагдах боломжгүй тасалбарууд байна.

Энэ нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" зэрэг заалтуудтай нийцэхгүй.

Өгсөн зөвлөмж: Цаашид ашиглах боломжгүй бараа материалыг зохих журмын дагуу шийдвэрлэн бүртгэлд үнэн зөв тусгах.

2. Бараа материал ангилалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын дансанд нэг жилээс дээш хугацаагаар ашиглагдах, үндсэн хөрөнгийн шинж чанартай 371 ширхэг, 147,675.0 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгүүдийг бүртгэсэн.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх", Сангийн сайдын 2025 оны 01-р сарын 03-ны өдрийн АЗ дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэл"-ийн журмын 3 бүлгийн 3.3 дахь заалт "Байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх эдийн засгийн үр өгөөжийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлсэн бөгөөд тэдгээрийг найдвартай хэмжиж болохоор байвал зардлыг хүлээн зөвшөөрнө" гэж заасантай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын дансанд бүртгэлтэй Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүдийг цаашид ашиглах боломжтой эсэхийг тогтоон, өмч хамгаалах байнгын зөвлөлдөө танилцуулан зохих шийдвэр гаргаж, данснаас хасах эсвэл дахин үнэлүүлж, өртөг ба цаашид ашиглах хугацааг тогтоолгох албан хүсэлт ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх.

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа 281,238.3 мянган төгрөгийн 6 ширхэг барилга, байгууламж, орон сууц, 167 ширхэг машин тоног төхөөрөмж (компьютер), 6 ширхэг тавилга эд хогшил, 1 ширхэг программ хангамжийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 онд баталсан "Журам шинэчлэх тухай" 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засан сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ." мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "үнэн зөв байх" гэж заасан заалтуудтай тус тус нийцэхгүй.



Өгсөн зөвлөмж: Цаашид элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр тайлагнах, ашиглах хөрөнгүүдийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-хүргүүлж шийдвэрлүүлэх.

4. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд Чингис Хаан Үндэсний Музейд ТӨБЗГ-ын 2023 оны 11-р сарын 09-ний өдрийн 568 дугаар тогтоол бүхий чиглэлийн дагуу 541 дэсийн 5,429 ширхэг 936,709.0 мянган төгрөгийн үнэ бүхий үзмэрүүдийг балансаас балансад шилжүүлсэн хэдий ч энэхүү шилжүүлсэн хөрөнгүүдтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн хэрэгжилтийг үл хүлээн зөвшөөрч бүртгээгүй.

Энэ нь ТӨБЗГ-н 2019 оны 271 дүгээр тогтоолын 9 дүгээр зүйлийн 9.1-д "Эрх бүхий байгууллагын шийдвэр, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хийсэн хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн болон хөрөнгийн үнэлгээний залруулгыг холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу данс бүртгэлд тусгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэж заасан заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Балансаас балансад шилжүүлсэн хөрөнгүүдийн дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгүүдтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн хэрэгжилтийг үл хүлээн зөвшөөрч бүртгэх.

5. Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ТӨБЗГ-ын 2023 оны 11-р сарын 09-ний өдрийн 568 дугаартай "Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай" тогтоолын дагуу Монголын Үндэсний Музейгээс Чингис Хаан музейд 975,542.1 мянган төгрөгийн үнэ бүхий музейн үзмэрүүдийг шилжүүлэх чиглэл ирсэн хэдий ч Монголын Үндэсний Музей нь 2025 оны 6-р сарын 11-ний өдрийн №127 бүхий албан тоотоор Чингис Хаан Үндэсний музейд 936,709.0 мянган төгрөгийн үнэ бүхий үзмэрийг шилжүүлсэн байна. Улмаар ТӨБЗГ-ын чиглэлийн дагуу шилжүүлэх үзмэрүүд, Чингис Хаан музейд шилжүүлсэн үзмэрүүдийн зөрүүг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" зэрэг заалтуудтай нийцэхгүй.

Өгсөн зөвлөмж: ТӨБЗГ-т хүсэлт илгээн зохих шийдвэрийг гаргуулан түүний дагуу шилжүүлсэн хөрөнгө болон шийдвэрийн зөрүүг тохируулах.

6. Музейн нэмэлт орлогын тооцоо нийлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Гэрээ байгуулан хамтран ажиллаж буй аялал жуулчлалын чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд үзүүлж буй дараа тооцооны буюу ваучерын бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой орлого дутуу илэрхийлэгдэх эрсдэлтэй байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" зэрэг заалтуудтай нийцэхгүй.

Өгсөн зөвлөмж: Ваучерын орлогын тооцоог нийлэхдээ гүйцэтгэлийг үзмэр үзэгчдийн тоо, хөнгөлөлтийн тоо, мөнгөн дүн, үлдэгдэл зэргийг хамт баталгаажуулах, ваучераар үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах.

7. Аккруэл сууриар зардал бүртгэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ашиглаж буй сайт, санхүүгийн болон кассын программ, и мэйл хаягийн жилийн хураамж, авто машины гэнэтийн ослын даатгалын төлбөрийг мөнгөөр төлсөн үедээ шууд зардалд нийт дүнгээр бүртгэснээс 557.7 мянган төгрөгийн зардлыг тайлант хугацаанд илүү бүртгэсэн.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх", 3.1.1."нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг, Сангийн сайдын 2025 оны 1 сарын 3-ны өдрийн АЗ дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэл"-ийн журмын 3 бүлгийн 3.3 дахь заалт "Байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх эдийн засгийн үр өгөөжийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлсэн бөгөөд тэдгээрийг найдвартай хэмжиж болохоор байвал зардлыг хүлээн зөвшөөрнө" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөр хураамжийн зардлыг гэрээний хугацаатай уялдуулан, гэрээний эрх үүссэн хугацаанаас эхлэн тооцоолол хийж, бүртгэл тайландаа аккурэл сууриар бүртгэх.

8. Түрээсийн гэрээтэй холбоотой асуудал


Илрүүлэлт: Автомашин түрээслэх гэрээнүүдийг шинэчлэхгүйгээр өмнөх гэрээг ашиглан байгуулсан байгаа нь тухайн ажилтай холбоогүй мэдээлэл гэрээнд тусгагдсан, үүрэг хариуцлага тооцох нөхцөлүүд нь тодорхой бус, зарим гэрээний гүйцэтгэгчийн гарын үсэг дутуу, ямар зардал санхүүжүүлэх нь тодорхойгүй байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 2 дугаар зүйлийн 20.2.4.-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй.

Өгсөн зөвлөмж: Байгуулж буй гэрээг үйлчилгээ тус бүрээр шинэчлэн хийж, гэрээний үүргийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				/мянган төгрөгөөр/	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХОАТ-ын илүү төлөлтийг хасах тэмдэгтэй өглөгөөр бүртгэсэн.	1	460.0	-	-	1	460.0	1	460.0	-	-	-	-
Музейн нэмэлт орлого буюу үйлчилгээний төлбөрийн илүү төлөлтийг хасах тэмдэгтэй авлагаар бүртгэсэн	1	797.3	-	-	1	797.3	1	797.3	-	-	-	-
Бараа материалыг ангиллын зөрүүтэй бүртгэсэн.	1	1,063.4	-	-	1	1,063.4	1	1,063.4	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнийг дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн дансад бус үнэ төлбөргүй хүлээн авсан орлогод бүртгэсэн.	1	52,641.7	-	-	1	52,641.7	1	52,641.7	-	-	-	-
Тавилга эд хогшил дансанд компьютер, бусад хэрэгсэл, бусад хөрөнгийг бүртгэсэн.	1	346,265.3	-	-	1	346,265.3	1	346,265.3	-	-	-	-
Музейн үзмэрийн орлого буюу үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг дутуу бүртгэсэн.	1	33,340.0	1	33,340.0			1	33,340.0	-	-	-	-
Татаас санхүүжилтийн авлагыг дутуу бүртгэсэн.	1	472,788.7	1	472,788.7			1	472,788.7	-	-	-	-
Авран хамгаалах судалгааны орлого, зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн.	1	10,000.0	-	-	1	10,000.0	1	10,000.0	-	-	-	-
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дансанд гэрэл цахилгааны төлбөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, дотоод томилолтын зардал зэргийн эдийн засгийн ангилал зөрүүтэй тайлагнасан.	1	10,673.9	-	-	1	10,673.9	1	10,673.9	-	-	-	-
Дүн	9	928,030.3	2	506,128.7	7	421,901.6	9	928,030.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Захирлын 2025 оны 10-р сарын 22-ны өдрийн А/149 тоот тушаалын дагуу томилолтоор ажилласан эрдэм шинжилгээний 2 ажилтанд үндсэн цалин, судлаачийн ажлын хөлсийг давхардуулан олгосон.	1	1,200.0	1	1,200.0						
Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ бүхий ажилтнуудад улирлын үр дүнгийн урамшуулал олгосон байна	1	2,151.4	1	2,151.4						
Дотоод томилолт, түүнтэй холбоотой гарсан зардлуудыг урьдчилж төлсөн тооцоогоор бүртгээгүй, зарцуулалтын баримтууд дутуу, зарцуулалтад хяналт тавьж баталгаажуулаагүй.	1	41,860.0			1	41,860.0				
Шатахууныг дараа тооцоогоор бүртгээгүй, зарцуулалтын баримтууд дутуу, зарцуулалтад хяналт тавьж баталгаажуулаагүй.	1	8,171.9			1	8,171.9				
Анхан шатны болон дэмжих нотлох баримтын бүрдэл хангалтгүй, бүрэн бус баримтыг үндэслэн зардал бүртгэсэн.	1	12,294.1			1	12,294.1				
Өндөр насны тэтгэвэрт гарч буй нэр бүхий нэг ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж олгохдоо төрийн албанд ажилласан жилийн нотлох баримтыг архивлаагүй, мөн нэр бүхий нэг ажилтанд 3,155.3 мянган төгрөгийг илүү тооцож олгосон.	1	52,953.4			1	52,953.4				
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Палеонтологи, археологийн авран хамгаалах зөвшөөрөл авах зорилгоор тус байгууллагад хөдөлмөрийн гэрээ байгуулсан хэдий ч ажилладаггүй судлаач, археологич, докторын зэрэгтэй нэр бүхий ажилтанд цалин, нэмэгдэл, урамшууллыг олгосон.	1	25,529.1			1	25,529.1				



Монголын Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нью жуулчин турс ХХК-ийн ваучерын орлого болох музейн үзмэрийн 33,340.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн бүртгэлд тусгалгүй, тус компанитай байгуулсан 2025 оны 2-р сарын 07-ны өдрийн ОУТ/SYX/250212-40 тоот Аялал жуулчлалын гэрээний төлбөрт хоорондын тооцоогоор хаасан.	1	33,340.0 ✓		1	33,340.0	1					1	-
Өмгөөллийн түрэг ХХК-тай "Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх" байгуулсан гэрээнд өмгөөллийн компанийн гүйцэтгэх үүрэг нь ерөнхий, ажлын даалгаврыг тодорхой тусгаагүйтэй холбоотой гэрээний үүргийн гүйцэтгэлийг хэрхэн дүгнэх нь тодорхой бус байна.	1	9,000.0		1	9,000.0							
Бараа материалын дансанд 2025 оны жилийн эцсээр 28,926 ширхэг 12,396.2 мянган төгрөгийн өртөг бүхий үнэт цаас бүртгэлтэй байгаа бөгөөд 2018-2022 онуудад орлогод авсан 10,310 ширхэг 4,020.0 мянган төгрөгийн өртөг бүхий цаашид ашиглагдах боломжгүй тасалбарууд бүртгэлтэй байна.	1	12,396.2 ✓				1	12,396.2					
Бараа материалын дансанд нэг жилээс дээш хугацаагаар ашиглагдах, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүдийг бүртгэсэн.	1	147,675.0 ✓				1	147,675.0					
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа 4 нэр төрлийн 180 ширхэг хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.	1	281,238.3 ✓				1	281,238.3					
Чингис Хаан Үндэсний Музейд балансаас балансад шилжүүлсэн хөрөнгүүдтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй.	1	- ✓				1	-					
ТӨБЗГ-ын 2023 оны 11-р сарын 09-ний өдрийн 568 дугаартай Чингис Хаан музейд "Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай" тогтоолын дүн Монголын Үндэсний Музейн 2025 оны 6-р сарын 11-ний өдрийн №127 бүхий албан тоотоор Чингис Хаан музейд шилжүүлсэн үнийн дүн зөрүүтэй	1	38,833.0 ✓				1	38,833.0					

Монголын Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аялал жуулчлалын чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд үзүүлж буй дараа тооцооны буюу ваучерын бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаар холбоотой орлого дутуу илэрхийлэгдэх эрсдэлтэй байна.	1	✓							1	-				
Ашиглаж буй сайт, санхүүгийн болон кассын программ, и мэйл хаягийн жилийн хураамж, авто машины гэнэтийн ослын даатгалын төлбөрийг зэргийг аккрузал сууриар бүртгээгүй.	1	557.7 ✓							1	557.7				
Автомашин түрээслэх гэрээнүүдийг шинэчлэхгүйгээр өмнөх гэрээг ашиглан байгуулсан байгаа нь тухайн ажилтай холбоогүй мэдээлэл гэрээнд тусгагдсан, үүрэг хариуцлага тооцох нөхцөлүүд нь тодорхой бус, зарим гэрээний гүйцэтгэлийн гарын үсэг дутуу, ямар зардал санхүүжүүлэх нь тодорхойгүй байна.	1	20,090.0 ✓							1	20,090.0				
Дүн	18	687,290.1	2	3,351.4	7	183,148.5	8	500,790.2	1	-				



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга		Нийт зөрчил		Үүнээс				/мянган төгрөгөөр/
				Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим системд орлогын 357,502.3 мянган төгрөгийн 6 гүйлгээг, зарлагын 900,747.8 мянган төгрөгийн 19 гүйлгээг мэдээлээгүй, мөн орлогын 264,685.2 мянган төгрөгийн 18 гүйлгээг, зарлагын 95,584.2 мянган төгрөгийн 19 гүйлгээг хугацаа хоцроосон, 14,173.8 мянган төгрөгийн 2 харилцагчийн худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй байна.		1	1,632,693.3	1	1,632,693.3	-	-	-
Дүн		1	1,632,693.3	1	1,632,693.3	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант онд гэрээт харуул хамгаалалт, дохиолол хамгааллын үйлчилгээний 2 багц 100,100.0 мянган төгрөгийн тендерийн бичиг баримтын техникийн тодорхойлолтод тусгагдсан тусгай шаардлагыг нотлох баримтын иж бүрдэл дутуу, ажлын даалгаварт дурдсан үзүүлэлтийг хангасан эсэхийг тодорхойлсон баримтгүй шаргаруулсан байна. Мөн худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд гаднаас хараат бус 3 гишүүн ажиллуулж, ажлыг дүгнэсэн актгүй, ажилласан цагийн бүртгэлийг үндэслэж 1,222.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна		1	101,322.4	1	101,322.4		101,322.4	
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд худалдан авалтаар Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд худалдан авалтаар 96,626.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Харьцуулалтын аргаар худалдан авалт хийх төсөвт өртгийн дээд хязгаараас давсан худалдан авалтыг харьцуулалтын арга гэж худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг журмын дагуу төлөвлөж тайлагнаагүй.		1	96,626.0	1	96,626.0		96,626.0	
Тус байгууллагад мөрдөгдөж буй НБББББ нь Соёлын сайдын 2022 оны 01-р сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан бодлого бөгөөд тус бодлогод хүчингүй болсон Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын хавсралт "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам", Сангийн Сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" болон "Санхүүгийн тайлангийн заавар" зэрэг тушаалуудын зааварчилгаа мөн үндсэн хөрөнгийн дансны ангилалд тус байгууллагын онцлогт тохирсон өв сангийн ангилал тусгагдаагүй зэргээс үзэхэд холбогдох бодлогын бичиг нь тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна		1	-			1	-	-
Дүн		3	197,948.4	2	197,948.4		197,948.4	-
Нийт дүн		4	1,830,641.7	3	1,830,641.7		1,830,641.7	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 76/A0150122

Улаанбаатар хот

САГ - 2026 /149/НА -СТА -ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын Үндэсний Музейн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээтэй 6 ажилтанд улирлын үр дүнгийн урамшуулал нийт 2,151,350.00 (хоёр сая нэг зуун тавин мянган гурван зуун тавь) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," зэрэг заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хасгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3. "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээтэй 6 ажилтанд олгосон 2,151,350.00 (хоёр сая нэг зуун тавин мянган гурван зуун тавь) төгрөгийг буруу шийдвэр гаргасан Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Д.Мөнхзаяагаар төлүүлж, Төрийн сан дахь Аудитын орлогын 1009000000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор гаргаж, нотлох баримтын хамт Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын Үндэсний Музейн захирал (Д.Отгонсүрэн), Захиргаа, төлөвлөлтийн албаны дарга (И.Будбаяр) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Э.МӨНХТОГТОХ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



Z:\Ark\2026\0225\SAAG-45.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 77/A0150122

Улаанбаатар хот

САГ-2026/149/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Музейн захирлын 2025 оны 10-р сарын 22-ны өдрийн А/149 тоот тушаалын дагуу томилолтоор ажилласан эрдэм шинжилгээний 2 ажилтанд үндсэн цалин, судлаачийн ажлын хөлсийг 1,200,000.00 (нэг сая хоёр зуун мянга зургаан зуу) төгрөгөөр давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 2025 оны 1 сарын 3-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэл"-ийн журмын 3 бүлгийн 3.3-т "Байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх эдийн засгийн үр өгөөжийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлсэн бөгөөд тэдгээрийг найдвартай хэмжиж болохоор байвал зардлыг хүлээн зөвшөөрнө" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн;" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан олгосон ажлын хөлс 1,200,000.00 (нэг сая хоёр зуун мянга мянга) төгрөгийг Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Д.Мөнхзаяагаар төлүүлж Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор гаргаж, нотлох баримтын хамт Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын үндэсний музейн захирал (Д.Отгонсүрэн)-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Э.МӨНХТОГТОХ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 380/А0150122

Улаанбаатар хот

СТГ-0006/49/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 357,502,300.00 (гурван зуун тавин долоон сая таван зуун хоёр мянга гурван зуун) төгрөгийн 6 гүйлгээг, зарлагын 900,747,853.94 (есөн зуун сая долоон зуун дөчин долоон мянга найман зуун тавин гурван төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн 19 гүйлгээг мэдээлээгүй, мөн орлогын 264,685,152.00 (хоёр зуун жаран дөрвөн сая зургаан зуун наян таван мянга нэг зуун тавин хоёр) төгрөгийн 18 гүйлгээг, зарлагын 95,584,200.00 (ерөн таван сая таван зуун наян дөрвөн мянга хоёр зуун) төгрөгийн 19 гүйлгээг хугацаа хоцроосон, 14,173,800.00 (арван дөрвөн сая нэг зуун далан гурван мянга найман зуун) төгрөгийн 2 харилцагчийн худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." 4.2.1.11-д. "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим системд байршуулах мэдээллийг бүрэн оруулаагүй, хугацаа хоцроож мэдээлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын Үндэсний Музейн захирал (Д.Отгонсүрэн), Санхүүгийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч (Д.Мөнхзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Э.МӨНХТОГТОХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 381/20/50122

Улаанбаатар хот

СНГ-0006/149/НА-СТА ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд өндөр насны тэтгэвэрт гарч, ажлаас чөлөөлөгдөхөд нэг удаагийн буцалтгүй тусламж олгохдоо нэр бүхий 1 ажилтны төрийн албанд ажилласан жилийн нотлох баримтыг архивлаагүй 52,953,442.50 (тавин хоёр сая есөн зуун тавин гурван мянга дөрвөн зуун дөчин хоёр төгрөг тавин мөнгө) төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөөлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д "анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Төрийн албанд ажилласан хугацааг тооцох үндсэн бичиг баримт нь хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэр байна. Үндсэн бичиг баримтыг үрэгдүүлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагаас олгосон лавлагаа эсхүл төрийн албанд ажилласан хугацааг тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэнэ" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өндөр насны тэтгэвэрт гарч буй ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж олгохдоо төрийн албанд ажилласан жилийн нотлох баримтыг архивлаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын үндэсний музейн захирал (Д.Отгонсүрэн), Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (Д.Мөнхзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Э.МӨНХТОГТОХ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ил хароо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

2: Alban Shewardlaga\2026\0125 SAG-67.Docx

1526180832



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 382/АУ/50102

Улаанбаатар хот

СЛГ-0026/143/НА-СТА-ПЧЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны болон дэмжих нотлох баримтын бүрдэл дутуу нийт 12,294,100.00 (арван хоёр сая хоёр зуун ерэн дөрвөн мянга нэг зуун) төгрөгийн гүйлгээ хийж зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д "анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нягтлан бодох бүртгэлд анхан шатны болон дэмжих нотлох баримтын бүрдэлгүй, бүрэн бус хангалтгүй баримтыг үндэслэн гүйлгээ хийж, зардалд бүртгэдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын үндэсний музейн захирал (Д.Отгонсүрэн), Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (Д.Мөнхзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 383/АД/50122

Улаанбаатар хот

СДГ-0026/149/НА-СТН-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмгөөллийн түрэг ХХК-тай "Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх" №01/56 тоот гэрээг 2025 оны 10-р сарын 01-ний өдөр, 3 сарын хугацаатай нийт 9,000,000.00(есөн сая) төгрөгөөр байгуулсан. Уг гэрээнд өмгөөллийн гэрээнд тусгагдсан ажлын даалгавар тодорхой бус байгуулж анхан шатны баримтын иж бүрдэл дутуу зардалд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д "анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцээгүй байна.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйлчилгээ авахаар байгуулж буй гэрээнд гүйцэтгэх үүрэг, ажлын даалгаврыг тусгаагүй, гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнээдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын үндэсний музейн захирал (Д.Отгонсүрэн), Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (Д.Мөнхзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Э.МӨНХТОГТОХ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-67.docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар

334/20150120

Улаанбаатар хот

СМ-2026/149/НА-СТ-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Палеонтологи, археологийн авран хамгаалах зөвшөөрөл авах зорилгоор байнгын ажлын байранд ажиллаагүй судлаач, археологич, докторын зэрэгтэй 1 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан нийт 25,529,078.00 (хорин таван сая таван зуун хорин есөн мянга далан найман) төгрөгийн цалин, нэмэгдэл, урамшууллыг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9. "хөдөлмөрийн гэрээ" гэж хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр ажил олгогч, ажилтан харилцан тохиролцсоны дагуу хийсэн тохиролцоог хэлнэ, 102 дугаар зүйлийн 102.1.3 дах заалт "Ажилтны үр чадварын түвшин, гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулсан байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд оролцоогүй судлаач, археологич мэргэжилтэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан цалин хөлс олгосон асуудлыг зохих журам, хуулийн дагуу шийдвэрлэж зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын Үндэсний Музейн захирал (Д.Отгонсүрэн), Захиргаа, төлөвлөлтийн албаны дарга (И.Будбаяр), Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (Д.Мөнхзаяа) нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Э.МӨНХТОГТОХ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardiaga\2026-0125 SAG-67.Docx





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 385/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/149/НАСТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь Нью жуулчин турс ХХК-ийн ваучерын орлого болох музейн үзмэрийн 33,340,000.00 (гучин гурван сая хоёр зуун жаран мянган) төгрөгийн орлогыг санхүүгийн бүртгэлд тусгаагүй, тус компанитай байгуулсан 2025 оны 2-р сарын 07-ны өдрийн OUT/SYX/250212-40 тóт Аялал жуулчлалын гэрээний зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь залилан байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.5 дах заалт "үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг дараах арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" 46.5.3-т "гадаад томилолтын зардлыг санхүүжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйл 14.4-т "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ", 14.4.5-д "бүх орлого", 14.4.6-д "бүх зардал", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 6.1 дэх заалт "Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого, түүний зарцуулалтыг сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүү байдлын тайлан, орлого зарлагын явцын мэдээнд оруулж, тухайн тайлант оны санхүүгийн болон үр дүнгийн тайланд тусгана" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даван гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Төсвийн орлого, зардлыг үнэн зөв тайлагнаагүй, орлогыг бүртгэл тайланд дутуу тайлагнадаг, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230


Z: Alban Shaardlaga\2026\125\SAAG-67.Docx

1575 00022

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын Үндэсний Музейн захирал (Д.Отгонсүрэн), Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (Д.Мөнхзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Э.МӨНХТОГТОХ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 386/00150122

Улаанбаатар хот

СМГ-0026/149/МА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авран хамгаалах судалгааны ажилд томилолтоор ажиллах хугацаанд түрээсэлсэн 3 автомашины шатахууныг олгохдоо жолоочийн тооцооны хуудас дахь машины марк, улсын дугаар нь зөрүүтэй, эхэлсэн, дууссан спидометрийн заалтгүй, километрийн заалтыг нотлох анхан шатны баримтгүйгээр нийт 8,171,900.00 (найман сая нэг зуун далан нэгэн мянга есөн зуу) төгрөгийн шатахууныг зардлаар бүртгэсэн. Жолоочийн тооцооны хуудсанд бичигдсэн автомашины дугаараар Smartcar.mn сайтаас тухайн машины маркийг тулгахад зөрүүтэй байгаа нь баримт бичгийг хуурамчаар үйлдсэн байж болзошгүй, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахууны зардлыг норм нормативд үндэслэн тооцоо боддоггүй, замын хуудас хөтөлдөггүй, нотлох баримын бүрдэл дутуу зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын үндэсний музейн захирал (Д.Отгонсүрэн), Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (Д.Мөнхзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Э.МӨНХТОГТОХ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 327/АО/50122

Улаанбаатар хот

САН-2026/149/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Археологийн судалгаа, угсаатны зүйн авран хамгаалах судалгааны ажлын хүрээнд албан томилолтоор ажилласан хугацаанд түрээсэлсэн автомашины түрээсийн төлбөр, туслах ажилтны хөлс нийт 41,860,000.00 (дөчин нэгэн сая найман зуун жаран мянган) төгрөгийг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгээгүй, зарцуулалтыг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийж шууд зардалд тайлагнасан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 6 дугаарын зүйлийн 6.1-д "аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2025 оны 1 сарын 3-ны өдрийн АЗ дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэл"-ийн журмын 3 бүлгийн 3.7 дугаар зүйлийн (г)-д "Зардлыг урьдчилан төлөх үед: Дт Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/, Кт Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, (д)-д Урьдчилж төлсөн зардалаас тайлант үед хэрэгжсэн үед: Дт Зардал /нэр төрлөөр/ Кт Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/ бүртгэнэ", Музейн Хөдөлмөрийн дотоод журмын 10 дугаар зүйл Албан томилолтын 10.3-д "Дотоод томилолтоор ажилласан ажилтан ажлын 3 хоногийн дотор музейн захиралд илтгэх хуудсаар танилцуулж дүгнүүлнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил гүйлгээг тооцооны дансаар бүртгэдэггүй, анхан шатны нотлох баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийж, бүртгэл тайланд тайлагнадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын үндэсний музейн захирал (Д.Отгонсүрэн), Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (Д.Мөнхзаяа) /нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Э.МӨНХТОГТОХ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 388/А0150122

Улаанбаатар хот

СМГ-2026/148/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гэрээт харуул хамгаалалт, дохиолол хамгааллын үйлчилгээний 2 багц 100,100,000.00 (нэг зуун сая нэг зуун мянган) төгрөгийн тендерийн бичиг баримтын техникийн тодорхойлолтод тусгагдсан тусгай шаардлагыг нотлох баримтын иж бүрдэл дутуу, ажлын даалгаварт дурдсан үзүүлэлтийг хангасан эсэхийг тодорхойлсон баримтгүй шалгаруулсан байна. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд гаднаас хараат бус 3 гишүүн ажиллуулж, ажлыг дүгнэсэн актгүй, ажилласан цагийн бүртгэлийг үндэслэж 1,222,400.00 (нэг сая хоёр зуун хорин хоёр мянга дөрвөн зуун) төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т "Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй оролцогчийг ерөнхий шаардлага хангагүй гэж үзнэ", 50 дугаар зүйлийн 50.1.2-т "ерөнхий гэрээний нэгдүгээр үе шатны, эсхүл энэ хуулийн 50.1.1-д зааснаас бусад тендер шалгаруулалтын үнэлгээний хороог таваас доошгүй", хуулийн 48 дугаар зүйлийн 48.5-д "Тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална", Тендерийн бичиг баримтын тендер шалгаруулалтын зааварчилгаа 15.6.2-д "Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээллийг маягтын дагуу ирүүлж 2024 оны 1-12 сард тасралтгүй төлсөн болохыг төрийн мэдээлэл солилцооны хур системээр дамжуулан шалгана" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл

зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны тухай хууль, журмыг мөрдөн ажиллаагүй дэмжих нотлох баримтын бүрдэлгүй, бүрэн бус хангалтгүй баримтыг үндэслэн сонгон шалгаруулалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын үндэсний музейн захирал (Д.Отгонсүрэн), Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (Д.Мөнхзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Э.МӨНХТОГТОХ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 389/20150122

Улаанбаатар хот

С.АТ-2026/149/НА-СТА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд худалдан авалтаар нийт 96,626,055.00 (өрэн зургаан сая зургаан зуун хорин зургаан мянга тэвчин таван) төгрөгийн хэвлэл, бараа болон цэвэрлэгээний материал, үзэсгэлэн дэглэлт, орчуулга, хуулийн зөвлөгөө үйлчилгээ, нээлтийн үйл ажиллагаа зэрэг ажил үйлчилгээг худалдан авсан. Харьцуулалтын аргаар худалдан авалт хийх төсөвт өртгийн дээд хязгаараас давсан худалдан авалтыг харьцуулалтын арга гэж худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг журмын дагуу төлөвлөж тайлагнаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийг дагуу зохион байгуулна", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах" журмын 3.1-т "Захиалагч тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралтын 2 дугаар маягтын дагуу цахим системд боловсруулж, журмын 2.7, 2.8-д заасан төлөвлөгөө батлуулах дарааллын дагуу холбогдох дээд шатны байгууллагад тухайн төсвийн жил дууссан даруйд цахим системээр тайлагнана" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт хийдэг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг журмын дагуу төлөвлөж, тайлагнадаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын үндэсний музейн захирал (Д.Отгонсүрэн), Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч (Д.Мөнхзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Э.МӨНХТОГТОХ



Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг